

Г.Баярмаа, Е.Батчулуун, Ө.Болорчимэг, Э.Мөнгөнтулга,
Р.Нямхүү, Т.Оюун, У.Туяа, М.Энхбаяр, А.Энхтогтох

ХҮН БА ОРЧИН

I

Ерөнхий боловсролын сургуулийн
1 дүгээр ангийн сурах бичиг

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамны
зөвшөөрлөөр хэвлэв.

Долоо дахь хэвлэл

СУРГУУЛИЙН НОМЫН САНД ОЛГОВ.
БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО.

Улаанбаатар хот
2020 он

DDC
371.32
X-822

Хүн ба орчин I: Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн сурах бичиг. /
Энхтогтох А., ба бус; Ред. Даваахүү Э. -УБ. 2014. -68х./

Энэхүү сурах бичиг нь “Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулиар хамгаалагдсан бөгөөд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас бичгээр авсан зөвшөөрлөөс бусад тохиолдолд цахим болон хэвлэмэл хэлбэрээр, бүтнээр эсхүл хэсэгчлэн хувилах, хэвлэх, аливаа хэлбэрээр мэдээллийн санд оруулахыг хориглоно.

Сурах бичгийн талаарх аливаа санал, хүсэлтээ textbook@mecs.gov.mn хаягаар ирүүлнэ үү.

© Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам

ISBN 978-99973-69-43-7

ГАРЧИГ

Өмнөх үг

1.1. ӨӨРИЙГӨӨ МЭДЬЕ	5
Миний бие	6
Миний нэг өдөр	17
Бид юу сурсан бэ?	22
1.2. ХАРИЛЦЪЯ, ХАМТАРЪЯ	23
Манай гэрийнхэн	24
Миний гэр орон	28
Бид юу сурсан бэ?	30
1.3. СУРГУУЛЬТАЙГАА ТАНИЛЦЪЯ	31
Сургуулийн гадаад орчин	32
Сургуулийн дотоод орчин	35
Бид юу сурсан бэ?	40
1.4. ОРЧНОО АЖИГЛАЖ, СУДАЛЪЯ	41
Орон нутаг ба хүмүүс	42
Орон нутаг ба байгаль	47
Бид юу сурсан бэ?	52
1.5. БАЙГАЛИЙН ҮЗЭГДЛИЙГ АЖИГЛАЯ	53
Өдөр ба шөнө	54
Жилийн дөрвөн улирал	59
Бид юу сурсан бэ?	67

ӨМНӨХ ҮГ

Хүүхдүүд ээ! Та нарт хичээлийн шинэ жилийн баярын мэнд хүргэе.

Энэ хичээлийн жилд та нар “Хүн ба орчин” хичээлээр

- Байгаль, нийгмийн юмс үзэгдлийг сонирхон судлах;
- Бусадтай харилцах;
- Эрүүл мэндээ хамгаалах зэрэг мэдлэг, чадвар эзэмшиж зөв дадал хэвшилд суралцах болно. Үүний тулд:
 1. Орчин тойрноо ажиглах, асуулт асуух, таамаглал дэвшүүлэх
 2. Юуг, яаж судлахаа төлөвлөж тэмдэглэл хөтлөх
 3. Дасгал, даалгавар, туршилтыг хийж гүйцэтгэх
 4. Хийсэн ажлынхаа үр дүнг бусдадаа танилцуулж тайлбарлах гэсэн сурах арга барилын дөрвөн үйлд шатлан суралцана.



Судлах зүйлийн талаар асуулт асуух, таамаглал дэвшүүлэх



Юуг, яаж судлахаа төлөвлөх, тэмдэглэл хөтлөх



Дасгал, даалгавар, туршилт хийж гүйцэтгэх



Хийсэн ажлынхаа үр дүнг танилцуулах

1

ӨӨРИЙГӨӨ МЭДЬЕ



★ Миний бие

★ Миний хичээлийн хэрэглэл

★ Миний нэг өдөр

★ Бид юу сурсан бэ?

ЮУ МЭДЭРСЭН БЭ?



“Жигмэд, Тогмид хоёр” дууг дуулаарай.



Дасгал 1. Жигмэд, Тогмид хоёр эдгээр зүйлийг яаж таньж мэдсэн бэ? Харгалзуулаарай.

ЮУ ХАРСАН БЭ?



Тогмид юу харсан бэ?



Дасгал 1. Ижил ба ялгаатай шинжийг олоорой.

1. Ижил өнгийг ялгаарай.



2. Ижил дүрсийг нэг өнгөөр ялгаж будаарай.



3. Аль нь том, аль нь жижиг байна вэ?




4. Байрлал өөрчлөгдсөн байна уу?




НҮДЭЭ ХАМГААЛЪЯ

Аль нь зөв бэ? Тэмдэглээрэй.



ЯМАР АМТТАЙ ВЭ?

Жигмэд ямар амт мэдэрсэн бэ?



Амтыг яаж мэдэх вэ? Туршъя.

Дасгал 1. Ямар амттай вэ?

Амттан	Амт	Яаж мэдсэн бэ?
Ус		
Тараг		
Алим		

Дасгал 2. Амт нь ялгаатай юу?

Чацаргана	Давс	Зайрмаг	Тараг

Дасгал 3. Чиний идэх дуртай амттан юу вэ? Нэрийг нь хэлээд алхаарай.

Дасгал 4. Чиний сонгосон амттан эрүүл мэндэд ямар ач тустай вэ?


ШҮДЭЭ УГААЖ ХЭВШЬЕ

Дасгал 1. Шүдээ хэзээ угаах вэ? Хамтарч ярилцаарай.


А. Шүд угаахад юу хэрэгтэй вэ?



Б. Яаж угаах вэ?



В. Аль нь зөв бэ? Зөв , буруу гэж тэмдэглээрэй.



ЯМАР ҮНЭРТЭЙ ВЭ?

Жигмэд, Тогмид хоёр ойд ороод ямар үнэр мэдэрсэн бэ?

Юуны үнэр вэ?

Туршилт 1.



Арц



Алим



Жүрж



Ааруул




Ам, хамрын алчуурыг зөв хэрэглэж хэвшээрэй.

ЮУ СОНССОН БЭ?



Жигмэд, Тогмид хоёрт ойд юуны дуу сонсогдсон бэ?



Дасгал 1. Ямар дуу чимээ сонсогдох вэ? Чанга уу? Сул уу?



Дасгал 2. Энэ зөв үү, буруу юу? Яагаад вэ?



ЮУГААР ХИЙСЭН БЭ?



Цүнхэнд юу байгаа бол?



Дарааллын дагуу хийж туршъя.

1

Юу байгаа бол?



2

Тэмтэрч үзье.



3

Өө бамбарууш байна.



4

Юугаар хийсэн бэ?



ЯМАР ШИНЖТЭЙ ВЭ?



Дасгал 1. Тодорхойлоорой.

Хатуу байна шүү.

.....

Хэврэг юмаа...


!

.....

ГАРЫН АРИУН ЦЭВЭР САХЬЯ




Ялгааг ажиглаарай.



Дасгал 1. Элсээр тоглоцгооё. Багшийн зааврыг дагаарай.


Дасгал 2. Гараа хэзээ угаах вэ? Зургийг харж ярилцаарай.



ГАРАА ЗӨВ УГААЯ



Гараа дарааллын дагуу тогтмол угааж хэвшээрэй.



МӨРДӨЖ СУРЪЯ



Багштайгаа хамтарч цагийг уншаарай.



Дасгал 1. Хэдэн цагт юу хийж болох вэ? Зургийг хараад цэгийн оронд цагийг нөхөж бичээрэй.



Цаг: 10:00



Цаг: :



Цаг: :



Цаг: :



Дасгал 2. Багш, эцэг эхийнхээ тусламжтай “Миний өдрийн дэглэм” зохиож мөрдөөрэй.



1



2



3



4



5



6

ЧӨЛӨӨТ ЦАГАА ЗӨВ АШИГЛАЯ



Зургийг ажиглаарай. Хүүхдүүд юу хийж байна вэ? Эдгээрийг хэзээ хийж болох вэ? Ярилцаарай.



Дасгал 1. Асуултын дагуу ярилцаарай.

1. Чөлөөт цаг гэж юуг хэлж байна вэ?
2. Чөлөөт цагаараа юу хийх вэ?
3. Яагаад чөлөөт цагаа зөв өнгөрөөх хэрэгтэй вэ?


СУРАГЧИЙН ЦҮНХ




Бид ямар сонголт хийсэн бэ?




Цүнх



Дөрвөлжин шугамтай дэвтэр



Хичээнгүй бичгийн дэвтэр



Сурах бичиг



Ноотны дэвтэр



Шугам, харандаа, баллуур, үзүүрлэгч



Зургийн дэвтэр



Өнгийн цаас, хайч, цавуу



Биеийн тамирын хувцас



Хичээлийн хэрэглэлээ зөв хэрэглэж суръя.

Бичих



Үзгээ зөв барьж хичээнгүй цэвэр бичих

Унших



Номоо зөв тавьж унших

Хэмжих



Шугамын хэмжээг зөв унших

Зурах



Зургийн дэвтэрт зурах

Наах



Цавуу, цаасыг ариг гамтай хэрэглэх

Хайчлах



Зөв барьж хайчлах, хайчийг иш талаар нь дамжуулах



Дасгал 1. Зөв, аюулгүй, эмх цэгцтэй хадгалах талаар найздаа зөвлөөрэй.



БИД ЮУ СУРСАН БЭ?

1. Яаж таньж хэрэглэх вэ? Зураарай.



2. Чи хэдэн цагт унтах хэрэгтэй вэ? Тэмдэглээрэй. Тогтмол цагт унтах нь ямар ач тустай вэ?



3. Үүнийг найзтайгаа хамт бүтээе. Хэрэгтэй зүйлээ (✓) тэмдэглэж тавьж сонгоорой.



2

ХАРИЛЦЪЯ, ХАМТАРЪЯ



- ✿ Манай гэрийнхэн
- ✿ Миний гэр орон
- ✿ Бид юу сурсан бэ?

ГЭРИЙНХНЭЭ ТАНИЛЦУУЛЪЯ



Чи хэнд гэрийнхнээ танилцуулах вэ?



Асуулт асуух, зургийн цомгоор гэрийнхнээ танилцуулъя.



Дасгал 1. Асуултад хариулж багшийнхаа тусламжтай бичээрэй.

- Танай аавыг хэн гэдэг вэ?
- Танай ээжийг хэн гэдэг вэ?
- Эмээ, өвөөгийнхөө нэрийг бичээрэй
- Танай ах, эгчийн нэр хэн бэ?
- Дүүгийнхээ нэрийг хэлээрэй

Дасгал 2. “Манай гэрийнхэн” зургийн цомог бүтээж танилцуулаарай.

Миний эгч
тогооч



Миний ах
цагдаа



Миний ээж
эмч



Манай аав
жолооч



Дасгал 3. Чи гэрийнхнийхээ хэний утасны дугаарыг мэдэх вэ? Багшдаа хэлж өгөөрэй. Хүснэгтэд бичээрэй.

Нэр ээж	Утасны дугаар 99162135

Дасгал 4. Чи төрсөн өдрөөрөө хэнийг урих вэ? Найзынхаа утасны дугаарыг хэлээрэй.

ГЭРИЙНХЭНДЭЭ ТУСАЛЪЯ




Зургийг ажиглаарай.



Дасгал 1. Зургаас өөрийн хийж чадах зүйлийг сонгоно уу. Хэнд яаж тусалсан бэ? Найз нөхдөдөө тайлбарлаарай.



Дасгал 2. Дараах зураг ямар ялгаатай байна вэ? Гэр орноо цэвэр байлгахад чи яаж оролцдог вэ?




ДЭЭР БА ДООР




Эвтэй дөрвөн амьтны тухай үлгэрийг хэн сайн мэдэх вэ? Эвтэй байхын ач тусыг ярилцаарай.




Дасгал 1. Зургийг ажиглаарай.



Аль нь дээр байна вэ?



Аль нь доор байна вэ?



Дасгал 2. Хамгийн том ах нь аль вэ? Хамгийн бага дүү аль нь вэ?

Тэмдэглээрэй.



УРД БА АРД



Зургийг ажиглаарай. Ямар үлгэр вэ? Хамтын хүч, эв нэгдэл ямар тустай вэ?



Дасгал 1. Охины урд хэн хэн байна вэ? Тэмдэглээрэй.



Дасгал 2. Муурны ард юу байна вэ? Тэмдэглээрэй.



ТАНАЙХ ХААНА БАЙДАГ ВЭ?



Бат, Хулан, Цэцгээ, Болд дөрөв миний найзууд. Тэдний гэр нуурын аль талд нь байна вэ? Дөрвөн зүгийн зургийг ажиглаад ярилцаарай.




Дасгал 1. Хүснэгтэд дээрх зургаас байрлалыг олж зураарай.

Хэний гэр вэ? Нэрлээрэй.	Хойд	Өмнө	Баруун	Зүүн

БОЛГООМЖТОЙ ХАРЬЦААРАЙ



Зургийг харж ярилцаарай. Аль нь зөв , буруу үйлдэл вэ? Тэмдэглээрэй.



Дасгал 1. Хэрхэн болгоомжлох вэ? Ярилцаарай.



БИД ЮУ СУРСАН БЭ?

1. Чи гэрийнхнийхээ хэнд, яаж тусалдаг вэ? Жишээгээр тайлбарлаарай.
2. Захидал бичих дугтуйн нүүрэн дээр юу бичих вэ?



3. Гурван тоорой хаанаас хаашаа чиглэн алхаж байна вэ?
Баруунаас → Зүүн



Цэнхэр өмдтэй тооройн ард ямар өмдтэй тоорой явж байна вэ?

4. Гэрийн ард, баруун талд болон гэр дээр юу байна вэ?



5. Зурагт байгаа бидний өдөр бүр хэрэглэдэг зүйлийг нэрлээрэй. Хэрхэн болгоомжлох талаар найздаа зөвлөөрэй.

СУРГУУЛЬТАЙГАА
ТАНИЛЦЪЯ

- ✿ Сургуулийн гадаад орчин
- ✿ Сургуулийн дотоод орчин
- ✿ Бид юу сурсан бэ?

СУРГУУЛИЙН ХАЯГИЙГ МЭДЭЦГЭЭ



Чи сургуулийнхаа хаягийг мэдэх үү?

Би сайн мэдэхгүй. Багшаас асууж мэдэж авъя.



Дасгал 1. Багштайгаа хамтарч сургуулийнхаа хаягийг танилцуулж сураарай. Дэвтрээ зөв хаяглаарай.



ДЭВТЭР


Математик

..... /аймаг, хотын/

/сум, дүүрэг/ сургуулийн

ангийн сурагч

Дасгал 2. Гэрээс сургууль орохдоо тааралддаг зүйлээ нэрлээрэй.



СУРГУУЛИЙН ОРЧИН ДАХЬ ДУУ ЧИМЭЭГ СУДАЛЦГААЯ



Дараах тоглоомыг тоглоорой.

Бороо зөөлөн орлоо.

Бороо ширүүн орлоо.

Аадар бороо орлоо.

Бороо улам ширүүн орлоо.



Их олон янз сонсогдож байна

Надад нэг санаа байна.



Дараах газруудад ямар дуу чимээ сонсогдож байгааг судалцгаая.



Ангид



Сургуулийн гадаа



Сургуулийн хонгилд



Цайны газарт



Сургуулийн орчинд маш олон төрлийн дуу, чимээ гардаг. Зарим газар дуу чимээ их байна.



Дасгал 1. Хаана ямар дуу чимээ их сонсогдох вэ? Дүгнэлт хийгээрэй.



Багш нарын өрөө



Сургуулийн хонгил



Номын сан

Дасгал 2. Нэг хүүхэд нүдээ даавуугаар бооно. Харин нөгөө хүүхэд нь янз бүрийн зүйл ашиглан дуу гаргана. Гарч байгаа дуугаар нь юу болохыг нэрлээрэй. Хэн олныг нэрлэж чадсан бэ? Тоолоорой.



Дасгал 3. Хөгжим хийж сурцгаая.



Хатуу цаас авна. Зурагт үзүүлсний дагуу хайчилна.



Урт богино хэмжээтэй савх бэлтгэнэ.



Хатуу цаасан дээрээ савхаа байрлуулна. Савхаа цохиод үзээрэй.

АНГИД УРГАСАН УРГАМЛЫГ АЖИГЛАЖ СУРЦГААЯ




Ногоон ургамал дуу чимээг буруулдаг гэж сонссон.

Тэгвэл ургамал ямар хэсгүүдээс бүрддэг болохыг хамтран судалцгаая.



Дасгал 1. Ургамлын бүтцийн хэсгүүдийг нэрлэж бичээрэй.




Үндэс, иш, навч, цэцэг зэргийг ургамлын бүтцийн хэсгүүд гэнэ.

НАВЧ УРЛАЦГААЯ



Дараах навчуудыг ажиглаарай. Ямар ялгаатай байна вэ?




А.




Б.



Ангидаа байгаа хэд хэдэн ургамлын навчийг өсгөгч шилээр хараарай. Юуг ажигласан бэ? Ургамлын навч юугаараа ялгаатай байна вэ?



Дасгал 1. Дараах зургийг ажиглаад ижил хэлбэртэй навчуудыг зун, намрын өнгөөр ялган будаарай. Ямар өнгөөр будсан бэ? Тайлбарлаарай.



Ургамлын навч нь хэлбэр, хэмжээ, өнгө, судлаараа ялгаатай байдаг.

УРГАМЛЫН ЦЭЦГИЙГ АЖИГЛАЯ



Цэцгүүд ямар ялгаатай байна вэ?



Өнгө Дэлбийн тоо



Өнгө Дэлбийн тоо



Өнгө Дэлбийн тоо



Өнгө Дэлбийн тоо



Дасгал 1. Алтанзул, сарнайн цэцгийн ялгааг ажиглаарай.




Ургамлын цэцэг нь дэлбийн тоо, хэлбэр хэмжээ ба өнгөөрөө ялгаатай. Зарим цэцэг цоморлогтой байхад зарим нь цоморлоггүй байдаг.

ЦЭЦЭГ УРЛАЯ



Өнгөөр ялган будаарай. Ургамлын ямар хэсгийг будсан бэ? Нэрлээрэй. Ямар ялгаатай байна вэ?




Дасгал 1. Цэцэг урлаарай

Хэрэглэгдэх зүйлс:

- Шар өнгийн цаас
- Ногоон өнгийн цаас
- Ундааны гуурсан соруул (ишийг цаасаар ч хийсэн болно)
- Нарийн наалттай цаас

Үйл ажиллагааны дараалал:

1. Шар өнгийн цаасаар 5ш цэцгийн дэлбэ бэлтгэнэ.
2. Ногоон өнгийн цаасаар 5ш цоморлог бэлтгэнэ.
3. Ногоон өнгийн цаасаар 2ш навч бэлтгэнэ.
4. Цэцэгт ургамлыг бүтээхдээ цоморлогоо гуурсан иш дээр тогтооно.
5. Цоморлогийн дээрээс цэцгийн дэлбийг нэг нэгээр нь байрлуулна.
6. Бүтээсэн цэцгээ хараарай юу дутуу байна. Нэмээд урлаарай.




Дасгал 2. Ургамлын бүтцийн ямар хэсэг болохыг нь тохирох нүдэнд  тэмдэглээрэй


	Үндэс	Иш	Навч	Цэцэг	Үр жимс
					
					
					
					
					

БИД ЮУ СУРСАН БЭ?

1. Өөрийн хийсэн хөгжмийн савх модыг цохиод үзээрэй. Аль нь нарийн, бүдүүн сонсогдож байна вэ?



2. Ургамлын биеийн бүтцийн хэсгүүдийг нэрлээрэй.



3. Сургуулийнхаа хаягийг хэлээрэй.

ДЭВТЭР

Математик

..... /аймаг, хотын/

/сум, дүүрэг/ сургуулийн

ангийн сурагч

ОРЧНОО АЖИГЛАЖ,
СУДАЛЪЯ

- ☀ Орон нутаг ба хүмүүс
- ☀ Орон нутаг ба байгаль
- ☀ Бид юу сурсан бэ?

ГЭРИЙН ХАЯГАА ХЭЛЖ ӨГӨӨЧ



Гэрийнхээ хаягийг мэдэх үү? Ярилцъя.



Дасгал 1. Зургийг ажиглаад ярилцаарай.



Хашааны дугаар



Байрны дугаар



Дасгал 2. Гэрийн хаягаа хэлж сураарай.



Би Хэнтий аймгийн Биндэр сумын 5 дугаар багийн 15 тоот хашаанд амьдардаг.

Би Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 2 дугаар хорооны 6 дугаар байранд амьдардаг.



Дасгал 3. Найзынхаа болон хөдөө амьдардаг ах дүүсийнхээ хаягийг загварт тохируулан тодорхой хэлж сураарай.



..... аймгийн
 сумын
 багийн
 нутагладаг.

МИНИЙ ТӨРСӨН НУТАГ



Цэнгүүн, Номин хоёр цэцэрлэгт хүрээлэнд тоглож байгаад танилцжээ. Тэд өөрсдийнхөө амьдарч байгаа нутгийнхаа тухай ярилцав.



Би Улаанбаатар хотын Баянгол дүүрэгт амьдардаг.

Би хөдөө Сэлэнгэ аймгийн Алтанбулаг суманд амьдардаг.



Дасгал 1. Зургийн дагуу өөрийн нутагт байдаг бахархалт зүйлийн талаар ярилцаарай.



Нутгийн урлаг соёл



Зан заншил



Түүх дурсгал



Үзэсгэлэнт барилга

Дасгал 2. Зургаас өөрийн орон нутагт байдаг зүйлийг  гэж тэмдэглээд түүнийхээ тухай ярилцаарай.



Дасгал 3. Нутгийнхаа байгалийн үзэсгэлэнт ба дурсгалт газар, ан амьтны зураг болон мэдээлэл цуглуулаарай. Доорх дарааллыг баримтлаарай.

Хаана очсон бэ?

Юу мэдэж авсан бэ?

Чи юу сурсан бэ?

Дасгал 4. Цуглуулсан мэдээллээрээ “Миний нутаг” сэдэвт зурагт хуудас хийж багш, эцэг эхдээ танилцуулаарай.

НУТГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРУУД




Бид өдөр тутамдаа хэрэглэдэг эдгээр зүйлийг хаанаас авдаг вэ? Тэдгээр газрыг юу гэж нэрлэдэг вэ?



Дасгал 1. Хэн, хаана ажилладаг вэ? Зөв харгалзуулаарай.



Дасгал 2. Чи хаана очиж эдгээр зүйлийг авах вэ? Зөв харгалзуулаарай.



Хүмүүст үйлчилгээ үзүүлдэг газрыг нийтийн үйлчилгээний газар гэнэ.

ЧИ ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?



Дараах зургийг ажиглаад нэрлэж бичээрэй. Амьтан, ургамлыг ялгаарай.



Амьтан

Ургамал



Ургамал бидний амьдралд ямар ач тустай вэ? Зургийг хараад ургамлыг хэрхэн ангилж болох талаар ярилцаарай.



Дасгал 1. Чи алийг нь сонгох вэ?

Би жимс идэх дуртай.

Ягаад вэ?

1

2

3

4

5

6

7

8


Дасгал 2. Үр тарианы ургамлаар хийсэн хүнсний бүтээгдэхүүнийг ялгаж нэрлээрэй.

Дасгал 3. Чихэр бага ид гэдгийн учрыг ярилцаарай.

ГЭРИЙН ТЭЖЭЭВЭР АМЬДЫН АШИГ ШИМ



Зургийг ажиглаад амьтдын ашиг шимийн талаар ярилцаад тохируулан холбоорой.



Асуултын дагуу ярилцаарай. Малаас бид юуг нь авч ашигладаг вэ? Тэднийг хайрлаж хамгаалахын тулд бид юу хийж чадах вэ? Тэдэнд юу хэрэгтэй байж болох вэ? Хоол тэжээл бэлтгэх үү? Орон байр бэлтгэх үү?

Дасгал 1. Та нар гэртээ загас тэжээдэг үү? Тэжээдэг загасныхаа талаар бусдадаа ярьж өгөөрэй.



Аквариумд байгаа загасыг удаан харахад ядаргаа тайлагддаг гэж сонссон. Бас хөдөлгөөн бүрийг нь ажиглах нь нүдний дасгал хийсэн л гэсэн үг шүү.



- Юугаар хооллодог вэ?
- Яаж арчилдаг вэ?
- Хоол тэжээлийг нь өгөх, арчлахад юуг анхаарах вэ?



Дасгал 2. “Миний дуртай амьтан” бяцхан ном хийж бусдадаа танилцуулаарай.



Хүмүүс мал, амьтнаас ашиг шимийг нь авахын тулд гэршүүлж тэжээсэн амьтдыг гэрийн тэжээвэр амьтад гэнэ. Малаас хүний авч хэрэглэдэг зүйлийг ашиг шим гэнэ.

АМЬТДЫГ ХАЙРЛАН ХАМГААЛАХАД ЯАЖ ТУСЛАХ ВЭ?




Ямар амьтан хаана амьдардаг вэ? Тэдэнд үүр ямар хэрэгтэй вэ? Зураасаар холбоорой.



Дасгал 1. Ямар амьтан үүр оромжгүй байна вэ? Ямар амьтанд үүр хийж туслах вэ?

- Нохойд яаж үүр хийх вэ?
- Загасанд аквариум худалдан авахад юу анхаарах вэ?



БИД ЮУ СУРСАН БЭ?

1. “Манай нутаг сайхан” гэж яагаад нэрлэсэн бэ? Жишээг хэлээрэй.
2. Үйлчилгээний газраар үйлчлүүлэхдээ юуг анхаарах ёстой вэ? Зөв буруу үйлийг ялган тэмдэглээрэй.



3. Ургамлыг хэрэглэх байдлаар нь хэрхэн ангилах вэ? Нэрлээрэй.



4. Мал, амьтныг хамгаалахын тулд бид юу хийх хэрэгтэй вэ? Тоочиж бичээрэй.
 1.
 2.
 3.
 4.

БАЙГАЛИЙН ҮЗЭГДЛИЙГ АЖИГЛАЯ



- Өдөр ба шөнө
 - Жилийн дөрвөн улирал
- Бид юу сурсан бэ?

ӨГЛӨӨ, ӨДӨР, ОРОЙ



Дууг хамтдаа дуулаарай. Юуны тухай гарч байна вэ? Ярилцаарай.



Намайг дуудаж сэрээсэн
Гэгээн өглөө сайн байна уу?
Нарны гэрэлд гялалзсан
Гэрэлт цонхнууд сайн байна уу?



Зургийг ажиглаарай. Өглөө, өдөр, орой болж байгааг ялгаарай.



..... нар манддаг.



..... нар өндөрт хөөрнө.



..... нар жаргадаг.



Дасгал 1. Өглөө хүмүүс сэрдэг. Танай гэрийнхнээс хэн нь өглөө эрт сэрдэг вэ? Тэмдэглээрэй.

- | | | | |
|------------------------------|------------------------------|-------------------------------|-------------------------------|
| <input type="checkbox"/> аав | <input type="checkbox"/> ээж | <input type="checkbox"/> өвөө | <input type="checkbox"/> эмээ |
| <input type="checkbox"/> ах | <input type="checkbox"/> эгч | <input type="checkbox"/> дүү | <input type="checkbox"/> би |

Дасгал 2. Чи хэдэн цагт сэрдэг вэ?

Орой хэдэн цагт унтдаг вэ?

Дасгал 3. Зураг дээрх үйл явдлууд хэзээ болдгийг тохируулж холбоод ярилцаарай. Өөр ямар үйлдэл хийдэг вэ?

1. Хүмүүс өглөө бүр юу хийдэг вэ?
2. Хүмүүс өдөрт юу хийдэг вэ?
3. Хүмүүс оройд юу хийдэг вэ?



Өглөө



Өдөр



Орой



Өглөө нар мандахаас орой нар жаргах хүртэл өдөр үргэлжилнэ.

ӨДӨР ЯАГААД ДУЛААХАН БАЙДАГ ВЭ?



Дууг хамтдаа дуулаарай. Дуунд юуны тухай гарч байна вэ? Нартай өдөр яагаад гоё вэ? Ярилцаарай.



Цэцэг жимс дэлгэрч байна
Цэлмэг нартай өдөр гоё
Цэлмэг наранд бүгдээрээ
Цэнгэн наадах бас гоё
Аав нь ээж нь тавлаг байна
Алтан нартай өдөр гоё
Алтан наранд бүгдээрээ
Ажил сурах бас гоё



Хэзээ нартай байдаг вэ? Хэзээ сар, одод түгдэг вэ?



..... (Өдөр, шөнө)



..... (Өдөр, шөнө)



Дасгал 1. Аль нь гэрэл дулаан ялгаруулдаг вэ?

- А. Нар
- Б. Сар

Дасгал 2. Хүснэгтэд өдөр, шөнө гэсэн үгийн тохирохыг бичээрэй.

Дулаан	Сэрүүн

ШӨНӨ



Онъсого таагаарай.

Мөсөн дээр
Мөнгөн аяга (а, с, р)



Шөнө тэнгэрт юу харагддаг вэ? Ярилцаарай.



Дасгал 1. Шөнө гудамж, талбай, айлууд яагаад гэрлээ асаадаг вэ?



Нар жаргахаас маргаашийн нар мандах хүртэл шөнө үргэлжилнэ.

ШӨНӨ ЯАГААД СЭРҮҮХЭН БАЙДАГ ВЭ?



Халуун өдөр сэрүүцэхийн тулд гэрийн аль талд зогсох вэ? Яагаад вэ?



Өдөр ба шөнийг ялгаж будаарай.



Дасгал 1. Тохирох үгийг нөхөөрэй.

Нар туссан газар (дулаан, сэрүүн)

Нар тусаагүй, сүүдэр газар (дулаан, сэрүүн)

Дасгал 2. Зургийг ажиглаарай. Шөнө яагаад сэрүүхэн байдаг вэ?



ЯМАР УЛИРАЛ ВЭ?



Онъсого таацгаая.




Цаст гурван даваа
Найрт гурван даваа
Цэцэгт гурван даваа
Навчит гурван даваа
Тэр юу вэ?

Өвөл, хавар,
зун намар



Дасгал 1. Хаврын дараа ямар улирал болох вэ? Зурагт улирлын дарааллыг сумаар зураарай.


Дасгал 2. Зургийг ажиглаарай. Ямар улирал болж байна вэ? Байгальд ямар өөрчлөлт гарч байгааг ярилцаарай.



1



2



3



4



УЛИРЛЫН ОНЦЛОГ



Жилийн дөрвөн улиралд байгаль хэрхэн өөрчлөгдөх вэ?

Хавар цас хайлж цоохортоно.
Зун уул, тал ногоорно.
Намар өвс, ногоо шарлана.
Өвөл цас орж хүйтэрнэ.




Хавар, зун, намар, өвлийн улирлын онцлог юу вэ?



Дасгал 1. Хаврын улирал ямар онцлогтой вэ? Асуулт зохиож ярилцаарай.



Дасгал 2. Зурагт нэр өгч ярилцаарай. Өгүүлбэрийг нөхөөрэй.



Хүүхдүүд болохоор амарна.
Зун ургаж уул тал ногоорно.
(зун ургамал)

Дасгал 3. Асуултад хариулаарай.



Асуулт	Хариулт
Ямар улиралд модны навч шарлах вэ?	
Усны шувууд хэзээ буцах вэ?	
Ямар улиралд самар жимс боловсрох вэ?	

Дасгал 4. Ямар улирал вэ? Бичээрэй.



.....

Хүйтэн болно.


Цас орно.

Гол, горхи, нуурын ус хөлдөнө.

Дасгал 5. Зөв тохируулаарай.

- | | |
|----------|----------------------------|
| 1. Хавар | А. Цас орно. |
| 3. Зун | Б. Бороо орно. |
| 4. Намар | В. Цас мөс хайлна. |
| 5. Өвөл | Г. Жимс боловсордог. |
| | Д. Яргуй цэцэглэнэ. |
| | Е. Мод, өвс ногоо шарлана. |
| | Ё. Цэцэг дэлгэрнэ. |
| | Ж. Гол горхи хөлдөнө. |

Дасгал 6. Улирлыг дарааллаар нь бичээрэй.



УРГАМЛЫН НУУЦЫГ ОЛЪЁ



ХАВАР

Хаврын анхны цэцэг мөн үү?



Хавар яагаад ургамал ургадаг бэ?



ЗУН

Багваахай шөнө дэлбээгээ хумиж, өдөр дэлбээгээ нээдэг гэсэн үнэн үү?



Багваахайн үрийг үлээхэд хийсээд байна.



НАМАР

Энэ их үр тариагаар юу хийдэг вэ?



Би жимс идэх дуртай. Өвөө намайг намар жимс боловсорч гүйцэхээр нь идээрэй гэсэн. Нээрээ одоо өөр харагдаж байна шүү. Ямар учиртай юм бол?



ӨВӨЛ

Сонин шүү! Өвөл бүх ногоон ургамал хатаж үзэгдэхгүй болсон байхад гацуур мод ногооноороо байх юм. Үүнийг нь бэлэгдэж шинэ жилээр гацуур мод чимэглэдэг юм болов уу?





Дасгал 1. Хаврын хамгийн анхны ургамлын талаар юу мэдэх вэ?

Танай нутагт яргуй хэдэн сард цэцэглэж байгааг ажиглаад тэмдэглээрэй.



3

4

5

Дасгал 2. Багваахай яагаад зуны эхэн сард цэцэглэдэг вэ? Сургуулийнхаа гадаа гарч багваахайн цэцгийг ажиглаарай.

1. Хэдэн сард цэцэглэдэг болохыг тэмдэглээрэй.



5

6

7

2. Цэцгийн дэлбээ нь яаж ургасан байна вэ? (салж ургасан, нийлж ургасан гэх мэт)



3. Өдөр, шөнө, бороотой, салхитай өдөр багваахайн цэцэгт ямар өөрчлөлт гарч байна вэ? Ажиглаарай.

өдөр	шөнө	бороотой	салхитай

4. Эрвээхэй, цох зэрэг шавж багваахайн цэцэг дээгүүр нисэж бууж байдаг. Яагаад юм бол? Ярилцаарай.



5. Үр нь салхинд амархан хийсдгийн учрыг тайлбарлаарай. Яагаад?



Дасагл 3. “Ургац хураах” гэж юуг хэлдэг вэ? Хэзээ ургац хураадаг вэ? Яагаад?

Дасгал 4. Зурагт байгаа бидний өдөр тутам хэрэглэдэг хүнсний бүтээгдэхүүнийг юугаар хийдэг вэ?



Дасгал 5. Хүмүүс намар ургамлын харшил хөдөлдөг гэж ярьдаг. Яагаад?

Дасгал 6. Дараах эхийг уншаарай.

Унших сэдэв:

Урьд нэг цагт сайн санаат хараацай шувуу хүнийг үхэлгүй мөнх үүрдийн залуу болгохын тулд мөнхийн рашаан ус олоод хэдэн дуслыг амандаа балгаад нисэж явав гэнэ. Гэтэл хорт муу санаатай хэдгэнэ үүнийг мэдээд хараацайг нисэн явах зуурт нь час хийтэл хатгаж орхижээ. Хараацай шувуу өвдөхийн эрхээр дуу тавин ёолоод аман дахь мөнхийн усаа асгаж орхисонд тэр нь нарс, гацуур, аньс гурав дээр дусжээ. Ийм учраас энэ 3 ургамал мөнх ногоон навчтай болсон гэдэг.



Гацуур



Аньс



Нарс

Дасгал 7. Мөнх ногоон ургамлын навч өвөл унах уу? Багштайгаа хамтран ярилцаарай.

- А. Тийм
- В. Үгүй
- С. Зарим нь навч нь унаж байхад зарим нь ургаж байдаг.

БИД ЮУ СУРСАН БЭ?

1. Зөв хариултыг олоорой.

Шөнө ба өдрийн аль нь дулаан бэ? Учрыг тайлбарлаарай.

- А. Өдөр
- Б. Шөнө

2. Шөнө ба өдрийн аль нь сэрүүн бэ? Хувцсаа яаж тохируулах вэ? Ярилцаарай.

3. Зургийг будаарай. Энэ ямар улирал вэ?



4. Ургамлын улирлын өөрчлөлтийг зөв харгалзуулаарай.

- | | |
|-------|-------------------------|
| Зун | Яргуй цэцэглэнэ. |
| Намар | Модны навчис унана. |
| Өвөл | Багваахай цэцэглэнэ. |
| Хавар | Ургамал ногоо хагдарна. |

ХҮН БА ОРЧИН

I

Ерөнхий боловсролын сургуулийн
1 дүгээр ангийн сурах бичиг

Зохиогчийн баг

Ахлагч:	А.Энхтогтох
Гишүүд:	Г.Баярмаа
	Е.Батчулуун
	Ө.Болорчимэг
	Э.Мөнгөнтулга
	Р.Нямхүү
	Т.Оюун
	У.Туяа
	М.Энхбаяр

Редактор:	Э.Даваахүү
Техник редактор:	Б.Баярмаа

Хэвлэлийн эх бэлтгэгч: С.Сэржмядаг

Формат 84x108/16
Офсет хэвлэл. Офсет хэвлэлийн цаас. 80 гр/м²
Хэвлэлийн хуудас 8 х.х

Хэвлэлийн эхийг “Бест Колор Интернэшнл” ХХК-д бэлтгэж,
“Соёмбо принтинг” ХХК-д 35000 хувь хэвлэв.